



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

“Солонго экспресс” ХК-ийн нэгдмэл сонирхолтой¹
хувьцаа эзэмшигчдээс хувьцааг худалдан авах
саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11, 34.1 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 57 дугаар зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Солонго экспресс” ХК-ийн нийт гаргасан 156,523 ширхэг хувьцааны 87,86 хувь буюу 137,528 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох Люке Лесли, Абдулла Манзура, Ореллана Эрик Пабло нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 12,14 хувь буюу 18,995 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1,328 /нэг мянга гурван зуун хорин найм/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2012 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. Холбогдох хууль, журмын дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, хувьцааг худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан хувьцааг худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй этгээд /Люке Лесли/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001511